

## **2**

### **ДЭЛХИЙ САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН ХЯМРАЛЫГ ДАВАН ТУУЛАХАД ЗҮҮН ХОЙД АЗИД МОНГОЛ УЛСЫН ГҮЙЦЭТГЭХ ҮҮРЭГ**

**Д.Моломжамц**

Дэлхий нийт хэзээ хэзээнээс илүү глобальчлагдаж байгаа өнөө үед дэлхий дахиныг хамарсан санхүү, эдийн засгийн хямралаас ганц нэг улс орон дангаараа гарах, эсвэл хямралд өртөхгүй байх ямар ч боломжгүй нь тодорхой юм. Иймээс хамтын хүчээр, өөрөөр хэлбэл өөр хоорондоо зохицон уялдсан бодлого, тодорхой хөтөлбөр, хамтын ажиллагааны үр дүнд хямралыг хохирол багатай даван туулах болно. Ийм цаг үед Зүүн хойд азийн бүс нутагт оршиж буй улс орнуудын үр бүтээлтэй, идэвхтэй хамтын ажиллагаа нь эдийн засгийн хямралын цохилтыг зөөллөх, улмаар түүнийг хохирол багатай даван туулахад чухал ач холбогдолтой юм.

#### **Дэлхийн эдийн засгийн хямралын Монгол улсад нөлөөлж буй байдал**


АНУ – ын ипотекийн зах зээлийн хямралаас үүдэлтэй тус улсын санхүү, эдийн засгийн хямралын нөлөөгөөр хөгжингүй орнуудын эдийн засаг хямралд өртөж улмаар хэрэглээ огцом буурсан билээ. Энэ нь үйлдвэрлэгч буюу нийлүүлэгч орнуудын экспортыг бууруулж улмаар дэлхийн зах зээл дэх түүхий эд, байгалийн баялагийн эрэлтийг багасгаж үнэ буурахад хүчтэй нөлөөлсөн билээ.

Манай улсын экспортын гол бүтээгдэхүүн болох зэсийн үнэ өнгөрсөн оны сүүлчээс эхлэн ихээхэн буурсан нь экспортод сөрөг нөлөө үзүүлж гадаад худалдааны алдагдал нэмэгдэхэд нөлөөлсөн юм. Тухайлбал, 2008 оны 4 - р сард 1 тонн нь 8684.93 ам. долларт хүрч байсан зэсийн үнэ 2009 оны 1 - р сард

3071.98 ам.доллар болж 2.8 дахин буурсан байна. Үүнтэй холбоотойгоор 2009 оны 2 - р сарын байдлаар манай улсын экспортын хэмжээ өмнөх оны мөн

үеэс 45.9 % - иар буурсан байна. Монгол улсын экспортын гол бүтээгдэхүүн зэсийн дэлхийн зах зээл дэх үнийн өөрчлөлтийг График № 1 - д үзүүлэв.

График №1



Эх сурвалж : <http://www.westmetall.com>

Энэ нь нэг талаас дэлхийн зах зээл дээрх зэсийн үнэ буурсан, нөгөө талаас эрэлттэй холбоотойгоор манай экспортлож буй зэсийн хэмжээ багассантай холбоотой. Ингэснээр манай улсын валютын нөөц буурч, улмаар үндэсний валют болох төгрөгийн ам.доллартай харьцах ханш суларсан, түүнчлэн улсын төсвийн орлого буурснаар нийгэм, эдийн засгийн тулгамдсан олон чухал асуудлыг шийдвэрлэхэд хүндрэл бэрхшээл учрах болсон юм. Манай улсын эдийн засгийн өсөлт 2008 онд 9 % байсан бол 2009 онд буурч 4-5 % (зарим эх сурвалж 2-3% гэж тооцож байгаа) болох төлөвтэй байна. Сүүлийн саруудад дэлхийн зах зээл дээрх зэсийн үнэ өсөх хандлагатай байгаа хэдий ч энэхүү өсөлт өмнөх шигээ удаан хугацаанд тогтвортой үргэлжлэх эсэх нь эргэлзээтэй юм. Тиймээс манай засгийн газар нийгэм – эдийн засгийн зөв бодлого явуулах нь юу юунаас чухал байна.

Манай улс өргөн хэрэглээний ихэнх бараа бүтээгдэхүүнийг гаднаас импортоор худалдан авдаг тул төгрөгийн худалдан авах чадвар суларсан нь бараа бүтээгдэхүүний үнийг нэмэгдүүлэхэд нөлөөлж ард түмний амьжирагаанд сөрөг нөлөө үзүүлэх болсон. Түүнчлэн сүүлийн 10 гаруй жилд дэлхийн эдийн засаг эрчимтэй өсөж ирсэн, дэлхийн зах зээл дээр манай улсын экспортын гол нэрийн бүтээгдэхүүн болох зэс, алт, ноолуурын үнэ өндөр байсан зэрэг таатай нөлөөлөл нь манай ДНБ – ий хэмжээг эрс нэмэгдүүлсэн юм. Эдийн засгийн энэ таатай үед хуримтлагдсан ихээхэн хэмжээний нэмэгдэл орлогыг Засгийн газар төрийн албан хаагчдын цалин хөлсийг өсгөх, тэтгэвэр тэтгэмжийг нэмэгдүүлэх зэргээр гол төлөв нийгмийн арга хэмжээнд зарцуулж улсын төсвийн зарлагыг хэт өсгөсөн нь дэлхийн санхүү, эдийн засгийн хямралтай цаг хугацааны хувьд давхцаж улс орны эдийн засгийн байдлыг ихээхэн хүндруулсан юм.

Мөн үүний зэрэгцээ 2006 – 2008 оны дунд үе хүртэлх хугацаанд манай улсад барилгын материалын үнэ ихээхэн нэмэгдэж үүнтэй

холбоотойгоор барилгын өртөг зардал болон орон сууцны 1м.кв талбайн үнэ өмнө байгаагүй дээд хэмжээнд хүрсэн юм. Тухайлбал, орон сууцны 1м.кв талбайн үнэ 2000 онд дунджаар 300 орчим ам. доллар байсан бол 2008 оны эхэнд дунджаар 900 орчим ам.доллар болж даруй 3 дахин өссөн байна.

Үүнд зах зээлийн эрэлтийн зэрэгцээ арилжааны банкуудаас орон сууцны зээлийг барилгын компаниуд болон иргэдэд орон сууцаар нь барьцаалан хавтгайруулан олгож байсан нь ихээхэн нөлөөлсөн байна.

Гэтэл сүүлийн жилүүдэд хямралын нөлөөгөөр хүн амын худалдан авах чадвар буурснаар орон сууцны борлуулалт багассан, энэ нь барилгын компаниудын үйл ажиллагаанд сөрөг нөлөө үзүүлсэн, үүнтэй холбоотойгоор арилжааны банкуудын зээлийн эргэн төлөлт буурсан зэрэг нь банкны активыг багасгаж үндсэндээ зээл олголт зогсоход хүргэсэн. Энэ нь эдийн засаг дахь “цусны эргэлт”-ийг удаашруулж хямрал гүнзгийрэхэд ноцтой нөлөөлж байгаа болно.

Иймээс 2008 оны төгсгөл, 2009 оны эхнээс Засгийн газраас төсвийн урсгал зардлыг эрс багасгах, үр ашиг багатай хөрөнгө оруулалтаас татгалзах, үндэсний валют-төгрөгийн худалдан авах чадварыг дээшлүүлэх, эдийн засгийн бүтцийг боловсронгуй болгох, үйлдвэрлэлийг дэмжих, ялангуяа орон нутагт мал аж ахуйн түүхий эдийг боловсруулах жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлж ажлын байрыг шинээр бий болгох, дотоодын хэрэгцээг хангах, импортыг орлох бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх, экспортыг нэмэгдүүлэх зэрэг зорилт тавин тодорхой хөтөлбөр төлөвлөгөө боловсруулан ажиллаж байна.

Үүний зэрэгцээ Дэлхийн банк, ОУВС болон донор орнуудаас хөнгөлөлттэй зээл тусламж авах, хөрөнгө оруулагчидтай гэрээ байгуулж олон жил хүлээгдсэн ашигт малтмалын томоохон орд газруудыг ашиглахаар төлөвлөж байна. Тухайлбал, 2009 оны 3 – р сард болсон хандивлагчдын уулзалтаар ОУВС – аас 224 сая ам. долларын, Дэлхийн банкнаас 60 сая ам. долларын, Азийн хөгжлийн банкнаас 50 сая ам.долларын, Япон улсаас 50 сая ам. долларын хөнгөлөлттэй зээлийг авахаар тус тус тохиролцсон, Засгийн газраас Канадын “Айвенхуу майнз ИНК” компанийтай Оюу толгойн орд газрыг ашиглах гэрээг эцэслэн байгуулсан зэргийг дурьдаж болно.

Иймээс Монгол улс Зүүн хойд Азийн бүс нутгийн улс орнуудтай нягт хамтран ажилласнаар зөвхөн хямралыг даван туулахад төдийгүй удаан хугацааны туршид эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах, орон нутгийн хөгжлийн хурдцыг нэмэгдүүлэхэд чухал ач холбогдолтой болно.

#### **Монгол Улсын эдийн засагт Зүүн Хойд Азийн улс орнуудын гүйцэтгэж буй үүрэг**

Монгол улсын эдийн засагт Зүүн хойд Азийн улс орнуудын гүйцэтгэж байгаа үүрэг, ач холбогдлыг харуулахын тулд тус бүсийн улс орнуудтай хийж байгаа гадаад худалдааны эргэлт, түүнчлэн манай улсад

бүс нутгийн улс орнуудаас оруулсан хөрөнгө оруулалт ба зээлийн хэмжээ, түүний өсөлт зэрэг эдийн засгийн хамтын ажиллагааны үзүүлэлтүүдийг авч үзье.

**A. Гадаад худалдааны эргэлт :**

Монгол улсын гадаад худалдааны эргэлтийг 2008 оны эдийн засгийн урьдчилсан дүнгээс авч үзвэл тус улсын нийт экспорт 2539.3 сая ам. доллар, нийт импорт 3615.8 сая ам. доллар болсон байна. Нийт экспортын худалдааны 64.7 % - ийг БНХАУ, 3.3 % - ийг ОХУ, 1.2 % - ийг БНСУ, 1.1 % - ийг Япон улстай тус тус хийсэн нь нийлбэр дүнгээрээ 70.3 % болж байна. Харин нийт импортын худалдааны 34.4 % - ийг ОХУ, 33.0 % -ийг БНХАУ, 6.6 % -ийг Япон улс, 5.4 % - ийг БНСУ-тай тус тус хийсэн нь нийлбэр дүнгээрээ 79.4 % болж байна.

**B. Гадаадын хөрөнгө оруулалт :**

Монгол улсад 1991 – 2008 онуудад нийтдээ 3.0 тэрбум орчим ам.долларын гадаадын хөрөнгө оруулалт орсон байна. Гадаадын хөрөнгө оруулалт 1991 онд 2.11 сая ам. доллар байсан бол 1996 онд 53.63 сая ам. доллар, 2001 онд 123.17 сая ам доллар болсон бөгөөд, 2006 онд 206.6 сая ам. доллар, 2008 онд 708.9 сая ам.доллар болж өсчээ. Дээрх хугацаанд Монгол улсад дэлхийн 100 орноос хөрөнгө оруулалт хийгдсэн бөгөөд эдгээрээс хамгийн их хөрөнгө оруулсан зургаан улсад нийт хөрөнгө оруулалтын 81.1 % нь ноогдож байна. (Хүснэгт № 1)

**Монгол улсад хөрөнгө оруулсан улс орнууд /сая ам. доллар/**

**Хүснэгт № 1**

д/д	Нэр	Дүн	Нийт дүнд эзлэх хувь, %-иар
1.	БНХАУ	1,679.1	55.7
2.	Канад	251.2	8.3
3.	БНСУ	185.3	6.2
4.	Япон	125.8	4.2
5.	Вержини арлууд (Англи)	101.1	3.4
6.	ОХУ	99.8	3.3
	Бүгд дүн	2442.3	81.1

Эх сурвалж : Гадаадын хөрөнгө оруулалтын газар

Дээрх хүснэгтээс үзвэл Монгол улсад хамгийн их хөрөнгө оруулсан зургаан улсын дөрөв нь БНХАУ, БНСУ, Япон, ОХУ зэрэг Зүүн хойд Азийн улс орнууд бөгөөд эдгээр улсуудын нийт хөрөнгө оруулалт нь 2090.0 сая ам.доллар буюу гадаадын нийт хөрөнгө оруулалтын 69.4 % - ийг эзэлж байна.

## В. Хөнгөлөлттэй зээл :

Монгол улсад 1991 – 2006 онуудад Олон улсын банк санхүүгийн байгууллага болон хандивлагч улс орнуудаас нийтдээ 1,661.5 сая ам. долларын хөнгөлөлттэй зээл олгосон байна. Үүнээс дээрх хугацаанд хамгийн их зээл олгосон зургаан улсад нийт зээлийн 39.5 % нь ноогдож байна. (Хүснэгт № 2)

Монгол улсад зээл олгосон улс орнууд /сая ам. доллар/ Хүснэгт № 2

д/д	Нэр	Дүн	Нийт дүнд эзлэх хувь, %-иар
1.	Япон	375.45	22.6
2.	ОХУ	104.15	6.3
3.	ХБНГУ	79.0	4.7
4.	БНХАУ	33.64	2.0
5.	Кувейт	33.36	2.0
6.	БНСҮ	30.95	1.9
	Бүгд дүн	656.55	39.5

Эх сурвалж : Гадаадын хөрөнгө оруулалт, гадаад худалдааны агентлаг

Дээрх хүснэгтээс үзвэл Монгол улсад хамгийн их зээл олгосон зургаан улсын тоонд мөн л Зүүн хойд Азийн улс орнууд бүгд багтсан байна. Эдгээр улс орнуудаас Монгол улсад олгосон хөнгөлөлттэй зээлийн нийт дүн нь 544.19 сая ам. доллар буюу нийт зээлийн 32.8 % -ийг эзэлж байгаа юм.

Монгол улс зах зээлд шилжсэн 1990 – ээд оноос хойшхи хугацааны гадаад худалдааны эргэлт, хөрөнгө оруулалт, зээл, тэдгээрийн өсөлт зэрэг эдийн засгийн хамтын ажиллагааны тоо баримтаас үзвэл (**нийт экспортын 70.3 %, нийт импортын 79.4 %, гадаадын нийт хөрөнгө оруулалтын 69.4 %, гадаадын хөнгөлөлттэй зээлийн 32.8 %**) манай улсын эдийн засгийн өсөлт хөгжилт, цаашдын чиг хандлагад Зүүн хойд Азийн бүс нутгийн улс орнууд чухал үүрэг гүйцэтгэж байгаа нь тодорхой байна. Өөрөөр хэлбэл манай улсын ирээдүйн хөгжлийн нэг чухал гарц бол Зүүн хойд Азийн бүс нутгийн улс орнуудтай цаашид нягт хамтран ажиллах явдал юм.

### **Зүүн хойд Азийн бүсийн хамтын ажиллагаан дахь Монгол улсын оролцоо:**

Монгол улсын эдийн засгийн тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх, эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангах нэг гол хүчин зүйл бол бүс нутгийн эдийн засгийн интеграцид бүрэн хамрагдах явдал юм. Дэлхий дахиньг хамарсан санхүү, эдийн засгийн хямралыг хохирол багатай даван туулахын тулд Зүүн хойд Азийн Бүс нутгийн улс орнууд хэзээ хэзээнээс илүү нягт хамтран ажиллах шаардлагатай болж байна. Иймээс бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагаанд оролцох Монгол улсын оролцоог юуны түрүүнд дараах байдлаар томъёолж болох юм. Үүнд :

1. Зүүн хойд Азийн улс орнуудын хил залгаа орон нутгийн худалдааг өргөжүүлэх.

Үүнд чөлөөт худалдааны бүс байгуулах, хил залгаа мужуудын бартерийн худалдааг дэмжих, улмаар чөлөөт худалдааны гэрээ байгуулах зэрэг асуудлыг нухацтай авч үзэх шаардлагатай.

Монгол улс ОХУ-тай хил залгаа “Алтан булаг” худалдааны чөлөөт бүс, БНХАУ-тай хил залгаа “Замын - Үүд” эдийн засгийн чөлөөт бүс байгуулахтай холбогдуулан тодорхой ажлуудыг хийж байна. Тухайлбал, дээрх бүсүүдийн хууль эрх зүйн орчин нөхцлийг хангахтай холбогдсон “Чөлөөт бүсийн тухай” болон “Алтанбулаг” худалдааны чөлөөт бүсийн эрх зүйн байдлын тухай Монгол улсын хуулиудыг 2002 оны 6-р сард, “Замын - Үүд” эдийн засгийн чөлөөт бүсийн эрх зүйн байдлын тухай Монгол улсын хуулийг 2003 оны 6-р сард тус тус УИХ -аас батлан гаргасан юм.

Чөлөөт бүсэд хөрөнгө оруулалтын таатай орчин бүрдүүлэх, дэд бүтцийг хөгжүүлэх зорилгоор улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2008 онд “Алтан булаг” худалдааны чөлөөт бүсэд 579.6 сая төгрөгийн өртөг бүхий 4 төсөл, “Замын - Үүд” эдийн засгийн чөлөөт бүсэд 1480.0 сая төгрөгийн 2 төсөл хэрэгжүүлэхээр төлөвлөж тодорхой ажлуудыг хийсэн байна. Түүнчлэн “Алтанбулаг” худалдааны чөлөөт бүсийн захирагчийн ажлын албанаас өөрийн улсын болон ОХУ, БНХАУ, Япон, БНСУ, АНУ-ын 80 орчим хуулийн этгээдэд 400 орчим га талбай түрээслүүлж 600.0 сая гаруй ам.долларын хөрөнгө оруулалтын гэрээ байгуулсан байна.

Манай Засгийн газраас 2009 онд чөлөөт бүсүүдэд нийтдээ 4.4 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийхээр төлөвлөөд байгаа бөгөөд үүний 72 % нь “Алтанбулаг”, 22 % нь “Замын-Үүд”, 4 % нь “Чойр”, 2 % нь “Цагааннуур” чөлөөт бүсэд тус тус ноогдож байна. /Эх сурвалж : “Монгол улсын 2009 – 2011 оны төсвийн төсөл” Монгол Улсын Засгийн Газар. УБ. 2008, 65, 135 - р тал/

**Монгол улсын уул уурхайн ашигт малтмалыг хамтран ашиглах.**

Манай улсын ДНБ – ий үйлдвэрлэлийг ихээхэн нэмэгдүүлэх, эдийн засгийн өсөлтийг түргэтгэх нэг чухал хүчин зүйл бол уул уурхайн салбарыг эрчимтэй хөгжүүлэх, түүний дотроос байгалийн асар их нөөц баялаг бүхий орд газруудыг бүс нутгийн болон хөгжингүй орнуудтай хамтран ашиглах явдал юм. Юуны түрүүнд дараах орд газруудыг үр ашигтай ашиглах асуудалд Засгийн газар нухацтай хандаж байна. (Хүснэгт № 3)

Үул уурхайн томоохон төслүүдийн үндсэн үзүүлэлтүүд			Хүснэгт №
Төсөл	Эрдэс	Нийт үйлдвэрлэл	Ашиглалтын хугацаа (жил)
Таван толгой	Нүүрс	6.4 тэрбум тонн	30
Оюу толгой	Зэс, алт, мөнгө	32.214 сая тонн зэс, 900.1 тонн алт	40

Төмөртэй	Төмрийн хүдэр	229.29 сая тонн	26
Асгат	Мөнгө	7.370 сая тонн	10
Дорнод	Уран	28.868 сая тонн	17
Гурван булаг - Мардай	Уран	17.177 сая тонн	11

Эх сурвалж : Монгол улсын Эрдэс баялаг, эрчим хүчний яам

Эдгээр 6 орд газрын төсөл тус бүрийн үргэлжлэх дундаж хугацаа 22.3 жил, хөрөнгө оруулалтын нийт хэмжээ нь 5.7 тэрбум ам.доллар, орд газруудыг ашигласнаар үйлдвэрлэх нийт бүтээгдэхүүний хэмжээ нь уурхайн ашиглалтын нийт хугацаанд 64 тэрбум ам. доллар болох юм. /Эх сурвалж : “Economic Modernization in Mongolia : The Impact of Tax and Regulatory Policies on the Mining Sector”. A Research and Analysis Report by Dr. Robert Shapiro and Sonecon, LLC, International Economic Advisory Firm. January 2009, p-5./

Манай улс эдийн засгийн хүч чадлын хувьд эдгээр орд газруудыг дангаараа ашиглах боломжгүй юм. Нөгөө талаас Зүүн хойд Азийн бүсийн улс орнууд бол Монголын байгалийн баялагийн гол хэрэглэгч - зах зээл нь билээ.

Тухайлбал Оюу толгойн орд газарт хөрөнгө оруулах гэж буй Канадын “Айвенхуу Майнз Инк” компани болон түүний хувьцааг эзэмшигч Английн “Рио Тинто” компани нь бүтээгдэхүүнээ БНХАУ-д экспортлохоор тооцоо судалгаа хийсэн байдаг. “Айвенхуу Майнз Инк” компани нь БНХАУ –ын зэс хайлуулах таван үйлдвэртэй арилжааны яриа хэлэлцээ хийсэн бөгөөд 2004 оны 6-р сард Jiangxi Copper Co. –той ойлголцлын санамж бичигт гарын үсэг зурсан байна. /Эх сурвалж : “Айвенхуу Майнз Инк” компанийд зориулж AMEC Ausenco Joint Venture (AAJV) –ийн бэлтгэсэн судалгааны материал. “Оюу толгой төсөл” Орд ашиглалтын цогцолбор төлөвлөгөөний хураангуй. УБ. 2005 он. 7-р тал/

Түүнчлэн уул уурхайн бусад орд газруудыг тус бүсийн бусад улс орнуудтай хамтран ашиглах нь тус бүсийн орон нутгийн хөгжилд эерэг нөлөө үзүүлнэ. Тухайлбал, Таван толгойн ордын одоогоор тогтоогдоод байгаа нүүрсний нөөц нь 6.4 тэрбум орчим тонн, үүний 1.8 тэрбум тонн нь коксжих нүүрс юм. /Эх сурвалж : Монголын уул уурхайн мэдээллийн нэгдсэн сан. <http://www.mining.mn/> Коксжих нүүрс нь гангийн үйлдвэрийн маш чухал түүхий эд бөгөөд энэхүү нүүрсний дэлхийн нийт хэрэглээний 54 орчим хувь нь Япон, БНХАУ, БНСҮ зэрэг Зүүн хойд Азийн улс орнуудад ноогдож байгааг бид харгалзах ёстой юм. Нүүрсний аж үйлдвэрлэлд тээвэрлэлтийн зардал онцгой байр суурь эзэлдэг билээ. Иймээс энэ бүс нутагт, газар зүйн байрлалын хувьд гол хэрэглэгч улс орнуудтай маш ойр энэхүү нүүрсний томоохон орд газрыг бид харилцан ашигтай хамтран ашиглах шаардлагатай байна.

Оюу толгой ба Таван толгойн орд газрууд нь Монголын өмнөд хэсэг болох Өмнөговь аймагт, Гурван булаг – Мардай, Дорнод зэрэг орд газрууд нь Монголын зүүн бүс болох Дорнод аймагт, Төмөртэйн орд нь Сэлэнгэ аймагт оршдог бөгөөд эдгээр нь газарзүйн байрлалын хувьд тус бүс нутгийн улс орнуудтай хамгийн ойр оршдог аймгууд юм. Монгол улсын байгалийн их нөөц баялаг бүхий эдгээр орд газруудыг БНХАУ, ОХУ, Япон, БНСУ –үүд хамтран ашигласнаар эдгээр улс орнуудын хил залгаа мужуудын дэд бүтцийг хөгжүүлж, ажлын байрыг нэмэгдүүлэхийн зэрэгцээ том аж үйлдвэрүүд нь харьцангуй хямд өртөг зардал бүхий түүхий эдээр удаан хугацааны туршид найдвартай хангагдах болно.

Харин Монгол улсын хувьд өмнөд болон хойд, зүүн бүсийн аймаг, орон нутгийн зам тээвэр, цахилгаан, усан хангамж зэрэг дэд бүтцийг хөгжүүлэх, орчин үеийн дэвшилтэт техник технологи нэвтрүүлэх, ажлын байрыг бий болгох, улс орон нутгийн төсвийн орлогыг нэмэгдүүлэх зэрэг давуу талтай юм. Энэ бүхний дүнд энэ бүс нутаг дахь улс орнуудын хамтын ажиллагаа өргөжиж, эдийн засгийн чадавхи эрс нэмэгдсэнээр хямралыг даван туулахад чухал нөлөө үзүүлнэ.

### **Мал аж ахуйн гаралтай түүхий эдийг боловсруулах жижиг, дунд үйлдвэрийг хамтран байгуулах.**

Манай улс одоогоор 43 сая орчим малтай бөгөөд энэ тоо 2009 оны эцэс гэхэд 50 орчим саяд хүрнэ гэж урьдчилан тооцож байгаа билээ. Монгол улс мал аж ахуйн гаралтай түүхий эд болох мах, сүү, ноос, ноолуур, арьс ширийг ихээхэн хэмжээгээр бэлтгэх боломжтой. Тухайлбал, манай улс 2007 онд 188.2 мянган тонн мах, 465.6 мянган тонн сүү, 19.2 мянган тонн ноос, 4.9 мянган тонн ноолуур, 7.2 сая ширхэг арьс шир үйлдвэрлэсэн байна. /Эх сурвалж : “Монгол улсын нийгэм, эдийн засгийн хөгжлийн 2004 – 2007 оны тойм” Монгол улсын Сангийн Яам. УБ. 2008, 50 - р тал /

Гэвч эдийн засгийн хямралаас үүдэн дэлхийн зах зээлд эдгээр түүхий эдийн үнэ унасан нь малчдын амьдралд хүндээр тусаж, хөдөө орон нутгийн эдийн засгийн хөгжилд сөрөг нөлөө үзүүлэх боллоо. Ийм нөхцөлд мал аж ахуйн

гаралтай түүхий эдээр эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж орон нутгийн хэрэгцээг хангах, улмаар экспортлох явдал нэн чухал зорилт болж байна.

Манай улсын экспорт үндсэндээ дэлхийн зах зээл дээрх зэсийн үнээс, импорт нефтийн үнээс ихээхэн хамааралтай байгаа нь тус улсын эдийн засгийн бүтэц ихээхэн өрөөсгөл байгааг харуулж байгаа юм. Иймээс манай Засгийн газраас ойрын хугацаанд хэрэгжүүлэхээр төлөвлөж буй томоохон зорилт бол улс орныхоо эдийн засгийн бүтцийг шинэчлэх тухай асуудал юм.

Дэлхий дахинд экологийн цэвэр бүтээгдэхүүний эрэлт хэрэгцээ эрс өсч буй өнөөгийн нөхцөлд манай улсын мал аж ахуйн гаралтай түүхий эдийг хамтран ашиглах нь ихээхэн ихээдүйтэй бөгөөд Зүүн хойд Азийн улс

орнуудын орон нутгийн хөгжил, иргэдийн амьжиргааг дээшлүүлэхэд чухал ач холбогдолтой болно. Бид Зүүн хойд Азийн улс орнуудтай хамтран орчин үеийн техник технологи бүхий жижиг, дунд үйлдвэрийг байгуулж, бүтээгдэхүүний чанарт ижил стандарт тогтоосноор зах зээлийг нэмэгдүүлж, орон нутгийн эдийн засгийн харилцааг идэвхжүүлэх боломжтой болох юм.

Манай улсын уул уурхайн баялаг, хөдөө аж ахуйн гаралтай түүхий эдийг зүүн хойд Азийн бүс нутаг дахь аж үйлдвэр өндөр хөгжсөн хөрш зэргэлдээ улс орнуудтай хамтран ашиглах, жижиг дунд үйлдвэрийг байгуулах, худалдааг өргөжүүлэх зэрэг өмнө дурьдсан өргөн боломжийг бид үр ашигтай хамтран ашигласнаар дэлхий нийтийн өмнө тулгарсан санхүү, эдийн засгийн хямралыг амжилттай даван түүлах болно.

## Ашигласан ном зүй.

1. “Чөлөөт бүсийн тухай” Монгол улсын хууль ;
  2. “Алтанбулаг” худалдааны чөлөөт бүсийн эрх зүйн байдлын тухай Монгол улсын хууль ;
  3. “Замын - Үүд” эдийн засгийн чөлөөт бүсийн эрх зүйн байдлын тухай Монгол улсын хууль ;
  4. “Монгол улсын 2009 – 2011 оны төсвийн төсөл” Монгол Улсын Засгийн Газар, УБ. 2008 ;
  5. “Монгол улсын нийгэм, эдийн засгийн хөгжлийн 2004 – 2007 оны тойм” Монгол улсын Сангийн Яам. УБ. 2008 ;
  6. Монгол улсын Эрдэс баялаг, эрчим хүчний яамны мэдээ
  7. “Монгол улсын 2008 оны эдийн засаг, нийгмийн статистикийн урьдчилсан мэдээ” Монгол улсын Үндэсний Статистикийн хороо. “Зууны мэдээ” сонин 2009. №13 (3085)
  8. Гадаадын хөрөнгө оруулалт, гадаад худалдааны агентлагийн тоо мэдээ
  9. “Дэлхийн ñàí õżż, ýäèéí çàñäèéí õÿì ðàë áà 1 1 í áî è óëñ” ñyäýâò Ç°äéºëäºº õóéçäèöüí èëðäýë. ““ 1 023(3586)
  10. Áì àðæàðàë. .Д, “Çżżí õí èä Áçèéí ÷ºëººò õóäæäàí û áýðý áà 1 1 í áî è” 1 ýúéððýé í èéäýí õí ðóí . ОÁ. 2007 ;
  11. 1 1 èí 1 æàí ö.Á, “Óºðí áº 1 ðóóëèëö” ОÁ. 2008 ;
  12. “Оюу толгой төсөл” Орд ашиглалтын цогцолбор төлөвлөгөөний хураангуй. ОÁ. 2005 ;
  13. “Economic Modernization in Mongolia : The Impact of Tax and Regulatory Policies on the Mining Sector”. A Research and Analysis Report by Dr. Robert Shapiro and Sonecon, LLC, International Economic Advisory Firm. January 2009 ;
  14. Mongolia Quarterly, World Bank. February 2009.  
<http://www.worldbank.org.mn>
  15. Монголын уул уурхайн мэдээллийн нэгдсэн сан. <http://www.mining.mn/>
  16. <http://www.westmetall.com>